



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

211 дүгээр байр, Их богд-2 гудамж, Өргөн 5 дугаар баг,
Баянговь сум, Баянхонгор аймаг, 64135
Цахим шуудан: khural@bayangovi.bkh.gov.mn

2023.09.29 № 1а/40
танай _____-ны № _____-т

「 **БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА** 「
Б.БАТАМГАЛАН ТАНАА

Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6425 дугаарт бүртгэгдсэн Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг өөрчлөн тогтоох тухай 15/01 дүгээр тогтоолыг хүргүүлэв.

Хавсралт. 3. хуудастай

ДАРГА  Т.АМАРЖАРГАЛ



642306078



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.09.26 № 1/4914
танай 2023.09.13-ны № 19/35 -Т

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Г.АМАРЖАРГАЛ ТАНАА**

Баянхонгор аймгийн Баянговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг өөрчлөн тогтоох тухай” 15/01 дүгээр тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн .6.4.25 дугаарт бүртгэж хүргүүлэв.



Х.НЯМБААТАР

151604310



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 15/01

Өргөн

Г Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн т
хувь хэмжээг өөрчлөн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2.2, дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 тоот хамтарсан тушаалыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 15 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын төвийн өрхийн ахуйн болон энгийн хог хаягдлын хураамжийн сард төлөх хувь хэмжээг 7000 төгрөг болгон өөрчлөн, бусад хувь хэмжээг өмнөх хувь хэмжээгээр тогтоож хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын хураамжийг тогтоосон хэмжээгээр айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас төсөвт төвлөрүүлэн, сумын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах ажлыг зохион байгуулж, төсвийг зориулалтын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (Б.Бат-Амгалан)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 12/10 дугаар тогтоол, 2023 оны 07 дугаар 07-ны өдрийн 14/05 дугаар тогтоолуудыг хүчингүйд тооцсугай.

4.Уг тогтоолыг "Захиргааны хэм, хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

5.Тогтоолыг хуулийн хугацаанд нь холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга (Б.Маасүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Г.АМАРЖАРГАЛ



648801078

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 2013 оны 09 дүгээр сарын 15 өдрийн
 ээлжит 15 дугаар хуралдааны 15/10
 тогтоолын хавсралт

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
 ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хог хаягдлын хураамж төлөх өрх, аж ахуй нэгжийн нэр /хог хаягдал гарах эх үүсвэр/	Хугацаа	Сард төлөх хураамж	Нийт төлөх хураамжийн дүн
1	2	3	4	5
1	Сумын төвийн өрх	Сар бүр	7000	84000
2	Хөдөөгийн багийн өрх	Жилд 1 удаа	3 000	3 000
3	Сургууль /гал тогоо, дотуур байр/	Сар бүр	40 000	480 000
4	Засаг даргын тамгын газар	Сар бүр	10 000	120 000
5	Соёлын төв	Сар бүр	10 000	120 000
6	Сургууль	Сар бүр	10 000	120 000
7	Цэцэрлэг	Сар бүр	10 000	120 000
8	Эрүүл мэндийн төв	Сар бүр	10 000	120 000
9	Эмийн сан	Сар бүр	10 000	120 000
10	ЗХ-ний 143-р тусгай рот	Сар бүр	50 000	600000
11	Цаг уур, холбоо	Сар бүр	10 000	120 000
12	Банк санхүүгийн байгууллага	Сар бүр	20 000	240 000
13	Шатахуун түгээх станц	Сар бүр	10 000	120 000
14	Дэлгүүр /Архины тусгай зөвшөөрөлтэй/	Сар бүр	15 000	180 000
15	Хүнс, барааны дэлгүүр /тусгай зөвшөөрөлгүй/	Сар бүр	10 000	120 000
16	Бэст хонгор ХХК дулаан хангамж	Ажиллаж байх хугацаанд	50 000	-
17	Ресторан, бар	Сар бүр	20 000	240 000
18	Буудал	Сар бүр	12 000	144 000
19	Цайны газар	Сар бүр	8 000	96 000
20	Үсчин	Сар бүр	6 000	72 000
21	Авто засварын газар	Сар бүр	10 000	120 000
22	Бусад хог хаягдал /нүүрс, хөр, барилга засвар, мал нядлагаа/	Дуудлагаар	25 000	-
23	Барилга байгууламжийн хог хаягдал	Сар бүр	50 000	-
24	Уул уурхайн болон бусад зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй /кемп/	Сар бүр	100 000	-